## 1. УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газар засаглалыг бэхжүүлэх зорилтын хүрээнд төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтээс гаргаж буй санал, санаачлагыг харгалзах замаар тэдний оролцоог нэмэгдүүлэх, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээнд шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зорилгоор дэлхийн улс орнуудын сайн дурын олон талт санаачлага болох Нээлттэй Засгийн Түншлэл (цаашид "НЗТ" гэх)-д 2013 онд нэгдэн орсон билээ. НЗТ-ийн гишүүн орны хувьд Монгол Улсын Засгийн газар төрийн үйлчилгээ нээлттэй, ил тод, иргэдийн оролцоотой, инновацийг дэмжсэн, эрүүл, аюулгүй нийгмийг бүрдүүлэхэд чиглэсэн байх зарчмыг хэвшүүлэх тодорхой зорилт тавин эрчимтэй ажиллаж байна.

Монгол Улсын 2030 он хүртэлх Тогвтортой хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилтуудыг тогтвортой засаглалыг хангах замаар хэрэгжүүлэх бөгөөд НЗТ-ийн ил тод байдлыг хангах, иргэдийг хүчтэй болгох, авлигатай тэмцэх, засаглалыг бэхжүүлэх зорилгоор шинэ технологийг нэвтрүүлж ашиглахад чиглэсэн зарчмыг баримтлан төр-хувийн хэвшил, иргэд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, олон улсын байгууллагатай хамтран түншлэн ажилласнаар Засгийн газарт ил тод, нээлттэй, хариуцлагатай, авилгаас ангид байх нөхцөл бүрдэх өндөр ач холбогдолтой юм.

Монгол Улс Нээлттэй засгийн түншлэлийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (II)-гөө өмнөх (2014-16) төлөвлөгөөнөөсөө суралцсан туршлага дээр үндэслэн, Монгол Улсын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тодорхойлсон зорилтуудыг харгалзан, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын манлайлал, Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн удирдлага дор, иргэний нийгмийн төлөөллийн өргөн оролцоотойгоор боловсрууллаа. Мөн Монгол Улс дахь Азийн сан, Дэлхийн банк техникийн болон санхүүгийн туслалцаа үзүүлсэн болно.

## 2. МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТӨЛӨӨХ ХҮЧИН ЧАРМАЙЛТУУД

Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний төсөл нь Монгол Улс 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн бодлого, тэргүүлэх зорилтоо тодорхойлсон цаг хугацаанд боловсруулагдаж байгаагаараа онцлогтой.

Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно[1] хэмээн

[1] Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал

зорьж байгаа бөгөөд, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-химі, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нийгмийн тогтвортой хөгжлийг хангахын тулд жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улс сайн засаглал, эргэн тайлагнах байдлыг сайжруулах чиглэлээр хийсэн шинэтгэлийн хүрээнд 2005 оны НҮБ-ын Авлигын эсрэг конвенцэд нэгдэн орж, авлигатай тэмцэх чиглэлээр олон хууль тогтоомжуудын төслийг боловсруулан гаргаж, хараат бус хяналтын механизмыг бий болгож, 2007 онд Авлигатай тэмцэх газрыг үүсгэн байгуулсан. Мөн мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай хууль (2012), Төсвийн тухай хууль (2011), Шилэн дансны тухай хууль (2014), Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хууль (2014), Захиргааны ерөнхий хууль (2015), Нийтийн сонсголын тухай хууль (2015), Өрийн удирдлагын тухай хууль (2015) зэрэг хуулийг батлан гаргах, Нээлттэй гэрээ, олон улсын төсвийн түншлэл (2005), Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (2006), Нээлттэй засгийн түншлэлийн санаачлага (2013) зэрэгт нэгдэн орох, Авлигын эсрэг парламентчидын дэлхийн байгууллагын салбарыг (2012) Монгол улсад байгуулах  зэрэг хүчин чармайлтуудыг гаргаж байна.

Эдгээр хүчин чармайлтуудаа үргэлжлүүлэн илүү ил тод, иргэдийн оролцоотой, хариуцлагатай, үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд НЗТ-ийн үйл ажиллагаа чухал хөшүүрэг нь болж, түүнийгээ Олон улсын түвшинд сайн туршлага хэмээн танилцуулах индэр нь байх юм.

Монгол Улс хоёр дахь ҮАҮТ-гөө НЗТ-ээс тодорхойлсон 5 үндсэн сорилтоос 4 сорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх дараахь тодорхой 13 зорилтот үйл ажиллагаа бүхий үүрэг амлалтуудыг хүлээж байна. Эдгээрээс “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн гар утасны аппликэйшн”, “Шилэн дансны системийг сайжруулах” гэсэн хоёр зорилт өмнөх ҮАҮТ-өөс үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, улам боловсронгуй болгохоор тусгаж байгаа бөгөөд НЗТ-ийн зарчим, шалгуурт нийцсэн “Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг  хангах эрх зүйн орчныг бий болгох”, “Уул уурхайн салбар дахь бенефициал өмчлөлийн талаарх мэдээллийн ил тод байдал” зэрэг зорилт, арга хэмжээг дэвшүүлэн тусгасанаараа онцлогтой.

НЗТ-ийн 2014-2016 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд 3 чиглэлийн 35 зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажилласан. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад буюу 2015 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “дунд хугацааны өөрийн үнэлгээний тайлан”, Олон Улсын НЗТ-ийн зарчим, шаардлагын дагуу хөндлөнгийн шинжээчдийн “хараат бус тайлан” гарсан. Хөндлөнгийн шинжээчдийн үнэлгээгээр Монгол Улсын НЗТ-ийн 2014-2016 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд

тусгагдсан 35 зорилт, арга хэмжээнээс 2 зорилт, арга хэмжээ "ОД" үнэлгээ авч Олон Улсын түвшинд сайн жишиг болж үнэлэгдсэн ч төлөвлөгөөг хэрэгжүүлэх шатанд Үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагаа хангалтгүй, Засгийн газар, иргэний нийгмийн хамтын ажиллагаа хангалттай бус гэж дүгнэгдсэн байна.

## 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНИЙ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үр дүн, 2014-2016 оны ҮАҮТ-ний хэрэгжилтийн тайлан, хөндлөнгийн шинжээчдийн хараат бус тайлан, олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан санал, санаачлагыг харгалзан НЗТ-ийн 2016-2018 оны ҮАҮТ-ний төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан, төлөвлөгөөний төсөлд тусгах зорилтын санал авах, боловсруулах, хэлэлцүүлэх, нэгтгэн эцэслэх бүхий л үе шатанд түншлэгч талуудын оролцоог бүрэн хангаж ажиллав.

Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний төсөлд тусгах тэргүүлэх чиглэл, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдэх арга зам, үүрэг амлалт нь төрийн байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн 80 гаруй төлөөллийг оролцуулан зохион байгуулсан 2 дахь Олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан зорилт, арга хэмжээний саналд үндэслэгдсэн болно.

3.1. **Хэлэлцүүлгийн тов.** Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны "Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцүүлэх, санал авах зорилгоор Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулахаар Хэлэлцүүлэг болох өдрийн товыг ҮАҮТ-ний төсөлд тусгах зорилтуудын хамт Засгийн газрын веб сайт /www.cabinet.gov.mn/, "Өдрийн сонин", "Үндэсний шуудан" сонингуудад нийтэлж, Монголын үндэсний олон нийтийн телевизээр олон нийтэд мэдээлсэн бөгөөд түүнчлэн, өөрийн веб хуудас /www.zasag.mn/tunshlel/, "OGP Mongolia" Facebook public group, иргэний нийгмийн байгууллагуудын бүртгэлтэй имейлийн жагсаалтаар түгээж, мэдээлсэн. Үүнээс гадна, http://www.news.mn/r/302589; http://www.today.mn/p/18572; http://mglradio.com/home/index.php?mid=fastnews&page=1&document_srl=141123 зэрэг веб сайтуудаар тус хэлэлцүүлгийн зарлал цацагдсан байсан.

3.2. **Урьдчилан зарлах.** 2016-2018 оны "Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцүүлэх, санал авах зорилгоор Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийн зарыг хэлэлцүүлэг болох өдрөөс 8 хоногийн өмнө урьдчилан дээр дурдсан байдлаар ҮАҮТ-ний төслийн хамт зарласан бөгөөд төлөвлөгөөний шинэчилсэн төслийг файл хэлбэрээр тогтмол нийтэлж, мөн веб сайтаас татаж авах хэлбэрээр байршуулж байв. Мөн, аймаг, орон нутгийн түвшинд хэлэлцүүлж, саналаа нэгтгэн ирүүлэх тухай албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бүх аймгийн Засаг дарга нарт ҮАҮТ-ний төслийн хамт хүргүүлсэн.

3.3. **Танин мэдүүлэх.** Олон нийтийн хэлэлцүүлгийн зарлал нь Нээлттэй засгийн түншлэлийн талаарх товч танилцуулга, мэдээллийг агуулсан байсан ба

дэлгэрэнгүй мэдээллийг “OGP Mongolia” Facebook public group-д нэгдэж, “@OGP_Mongolia” твиттер аккаунтыг дагаж, түүнчлэн холбогдох линкүүдээс //http://www.zasag.mn/tunshlel; http://www.opengovpartnership.org; http://www.opghub.org/profile тогтмол авах боломжтой гэдгийг дурдаж, олон нийтэд тогтмол сануулж байсан.

3.4. **Олон суваг ашиглах.** Дээр дурдсан байдлаар олон сувгийг ашиглаж олон нийтийн оролцоог хангах боломжийг бий болгох үүднээс биечилсэн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулснаас гадна хэлэлцүүлэгт оролцох тухай зарыг түгээхдээ ҮАҮТ-ний төсөлтэй танилцаж цахим хэлбэрээр буюу имейлээр саналаа ирүүлэх боломжтойг дурдсан бөгөөд зарим иргэний нийгмийн байгууллагаас имейлээр, зарим аймаг, орон нутгаас албан бичгээр саналаа ирүүлсэн юм.

3.5. **Хэлэлүүлгийн цар хүрээ.** ҮАҮТ-ний төсөлд өргөн хүрээний, төрөлжсөн санал, санаачлагыг тусгахын тулд төр, иргэний нийгэм, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл болон иргэдийн төлөөллүүдээс оролцуулан 100 орчим оролцогчидтой хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж, 80 гаруй оролцогчдоос бүрдсэн өргөн цар хүрээтэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд 5 талт төлөөллүүдийн тэгш оролцоог хангаж оролцуулснаараа онцлогтой.

3.6. **Баримтжуулалт, саналууд.** ҮАҮТ-ний төслийг НЗТ-ийн 5 сорилтын хүрээнд боловсруулсны дагуу Хэлэлцүүлгийг 5 бүлэгт хуваан өрнүүлсэн бөгөөд Ажлын хэсгийн гишүүд чиглэл чиглэлийнхээ дагуу бүлгийн хэлэлцүүлгийг чиглүүлэгчийн үүргээр удирдан явуулж, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэн гаргаж, ҮАҮТ-ний төслийн дараагийн хувилбарыг гаргав. Дараа нь цахим хэлбэрээр төр, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдээс бүрдсэн Ажлын хэсгийн гишүүдэд цахим хэлбэрээр хүргүүлж, мөн “OGP Mongolia” Facebook public group-д байршуулж байв. Мөн аливаа хурал, уулзалт, хэлэлцүүлгийн хураангуй тэмдэглэлүүдийг тус тус буулган баримтжуулсан болно.

3.7. **Хэрэгжүүлэх явцад хэлэлцүүлэх.** Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 65 дугаар тушаалаар байгуулан ажиллуусан юм. Харин Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тогтмол хуралдах, олон талт хэлэлцүүлэг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, хангуулах үүрэг бүхий өргөн хүрээний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг форум хэлбэрээр зохион байгуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төлөвлөж байна.

## 4. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нээлттэй Засгийн Түншлэлийн 2016-2018 оны “Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-ний төслийг хэлэлцэх Олон нийтийн хэлэлцүүлгийг 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллагууд болон хэвлэл мэдээллийн салбарын 80 гаруй төлөөллүүдийн оролцоотойгоор зохион байгуулсан.

Олон нийтийн хэлэлцүүлгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн дэд дарга Г.Ганболд нээж, “Нээлттэй Засгийн Түншлэл ба Монгол Улс” танилцуулгыг хийв.

Энэ удаагийн олон нийтийн хэлэлцүүлэгт компани, хувийн хэвшлийн томоохон төлөөлөл Худалдаа аж үйлдвэрийн Үндэсний танхимын ерөнхийлөгч Б.Лхагважав, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийөгч Б.Галаарид, 2014-2016 оны ҮАҮТ-ний Хараат бус хөндлөнгийн шинжээч З.Батболд, ИНБ-уудын төлөөлөл Г.Ундрал, Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга Д. Ганбаяр нар ирж оролцон, салбараа төлөөлөн үг хэлж, Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагаанд цаашид анхаарах үнэтэй санал, зөвлөмжүүдийг хэлсэн.

Хэлэлцүүлэгт оролцогчид өөр өөрсдийн чиглэлийн дагуу 5 салбар хуралдаануудад оролцон Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны ҮАҮТ-ний төсөлд тусгах зорилтын саналууд болон шинээр нэмэх саналуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлэн бүлгээр ажилласан. Төлөвлөгөөний төсөлд өмнөх /2014-2016/ ҮАҮТ-ний өөрийн болон хараат бус тайлангаас авсан зорилтот үйл ажиллагаанууд, бүх яамд, аймаг, орон нутгаас албан бичгээр хандаж авсан санал, 2016 оны 2 дугаар сард зохион байгуулсан Үндэсний зөвлөлийн хуралдаан болон өргөтгөсөн нээлттэй хэлэлцүүлгийн үеэр иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдээс гарсан саналууд, Дэлхийн банкнаас дэвшүүлсэн санал зэрэг **нийт 30 зорилтот үйл ажиллагааны саналыг** НЗТ-ийн 5 сорилтын хүрээнд ангилан тусгасан байсан. Хэлэлцүүлгийн үр дүнд нийт 25 зорилтот үйл ажиллагааны саналыг нэгтгэсэн юм.

## 5. НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 61 дүгээр захирамжаар Нээлттэй засгийн түншлэлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн Ажлын албаны ажлыг хянан зохицуулах, нэгтгэн дүгнэх үүрэгтэйгээр байгуулсан бөгөөд Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдын 207 дугаар захирамжаар өөрчлөлт оруулсан.

Одоогоор тус бүрэлдэхүүнд Үндэсний зөвлөлийн даргаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, гишүүдээр Сангийн яам, Хууль зүйн яам, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар, болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ерөнхийлөгч, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын Судалгааны төвийн ерөнхий захирал, Нээлттэй нийгэм хүрээлэнгийн гүйцэтгэх захирал нар, Нарийн бичгийн даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга ажиллаж байна.

Үндэсний зөвлөлийн анхны бүрэлдэхүүн нь Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн анхны /2014-2016/ Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг Үндэсний

зөвлөлийн хуралдааны шийдвэрээр батлан явуулж байсан бөгөөд удаах хуралдаанаа шинэчлэгдсэн бүрэлдэхүүнтэйгээр 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдөр хийж, анхны ҮАҮТ-ний хэрэгжилт, тайланг дүгнэн хэлэлцэж, дараагийн /2016-2018/ ҮАҮТ-г хэрхэн боловсруулж, ажиллах тухай өргөтгөсөн хэлбэрээр нээлттэй хэлэлцүүлгийг өрнүүлсэн юм. Зөвлөлийн хуралдаанд Нээлттэй засгийн түншлэлийн Ази, номхон далайн иргэний нийгмийн зохицуулагч, Шрея Басу, засгийн газар хариуцсан хөтөлбөрийн ажилтан Жак Махонни нар оролцож, өргөтгөсөн хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулсан юм.

Тус хуралдаанаас гарсан саналын дагуу 2016-2018 оны ҮАҮТ-ний төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, идэвхтэй ажилласны үр дүнд Үндэсний зөвлөл 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр ҮАҮТ-ний төсөлтэй цахим хэлбэрээр хүлээн авч, танилцаад, 5 дугаар сарын 31-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар танилцуулахад бэлэн болгосон юм.

Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-ний төслийн тухай танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаар ҮАҮТ-ний төслийг дэмжиж, Засгийн газрын гишүүдийн саналыг тусгасан бөгөөд Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, тавьсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан, биелэлтэд нь хяналт тавьж, үнэлгээ өгч ажиллахыг Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод даалгасан билээ.

Засгийн газрын гишүүдийн саналыг тусгасан нийт 12 зорилтот үйл ажиллагаа бүхий ҮАҮТ-ний төслийг Үндэсний зөвлөл 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр хуралдан хэлэлцэж, Үндэсний зөвлөлийн тогтоолоор 13 зорилтот үйл ажиллагаа бүхий ҮАҮТ-ний төслийг батлан албажуулав.

Үндэсний зөвлөл нь өөрийн ажиллах журамд заасан дүрмийн дагуу хуралдаж, 2016-2018 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахаас гадна, Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны ҮАҮТ-ний хэрэгжилтийн талаар тогтмол хуралдах, олон талт хэлэлцүүлэг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих үүрэг бүхий өргөн хүрээний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг форум хэлбэрээр зохион байгуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төлөвлөж байна.

## 6. МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН АМЛАЛТ, ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн II дахь Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд дараах 13 зорилтот үйл ажиллагааг Нээлттэй засгийн түншлэлийн 5

сорилтоос 4 сорилт[2]-ын хүрээнд дэвшүүлэв. Зорилтот үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцах эзэн, гол зорилтын хамтаар загвар хүснэгтэд буулган хавсаргав.

## НЗТ-ИЙН СОРИЛТ: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ

<table>
<tr><th colspan="3">ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮСНЭГТ</th></tr>
<tr><td colspan="3">ЧИГЛЭЛ: Төрийн үйлчилгээ</td></tr>
<tr><td colspan="3">ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУГААР, НЭР: 1. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшн</td></tr>
<tr><td colspan="2">Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо<br>/Шинээр дэвшүүлж буй зорилт уу эсвэл хэрэгжиж буй зорилт юм уу?/</td><td>2016.06.30- 2018.06.30; Хэрэгжиж буй зорилт</td></tr>
<tr><td colspan="2">Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг</td><td>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар</td></tr>
<tr><td colspan="2">Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр</td><td>ЗГХЭГ-ын дэд дарга,</td></tr>
<tr><td colspan="2">Газар, хэлтсийн нэр</td><td>ЗГХЭГ-ын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах газар</td></tr>
<tr><td colspan="2">Майл хаяг</td><td>-</td></tr>
<tr><td colspan="2">Утас</td><td>-</td></tr>
<tr><td rowspan="2">Бусад оролцогч талууд</td><td>Яам, агентлаг</td><td>Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага /бүх яам, агентлаг, нийслэл, аймаг, сум дүүргийн ЗДТГ/</td></tr>
<tr><td>Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд</td><td>Ардчиллын боловсрол төв ТББ<br>Нийгмийн хариуцлагын төлөөх түншлэл<br>Холбогдох бусад ИНБ</td></tr>
<tr><td colspan="2">Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт</td><td>Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11:11 төв 2013 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2014-2016 оны МУ-ын НЗТ-ийн ҮАҮТ-ний хэрэгжилтээр “од” үнэлгээ авсан юм. 11:11 төв нь иргэдээс ирсэн санал, гомдлын мөрөөр хариу өгдөг ч энэ нь үйлчилгээг сайжруулах түлхэц болж чадахгүй байна. 11-11 төвийн үйлчилгээний ил тод байдал, хүртээмж, чанарыг үйлчилгээ хүртэгч иргэдээр үнэлүүлдэг, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар хариуцан тайлагнадаг тогтолцоог сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан цахимжуулах зайлшгүй шаардлага гарч байна.</td></tr>
<tr><td colspan="2">Гол зорилт</td><td>Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшн нэвтрүүлснээр төрийн үйлчилгээ иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ил тод, чанартай, шуурхай болно.</td></tr>
<tr><td colspan="2">Үйл ажиллагааны товч тодорхойлолт<br>(140 тэмдэгтийн хязгаартай)</td><td>Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11 төвийн үйлчилгээнд “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшн нэвтрүүлэх, цахимжуулах, иргэдэд сурталчлах, ашиглалтыг идэвхжүүлэх.</td></tr>
<tr><td colspan="2">НЗТ-ийн аль сорилтод хамаатай болох</td><td>Төрийн үйлчилгээг сайжруулах</td></tr>
</table>

[2] Олон Улсын Нээлттэй засгийн түншлэлээс дэлхийн улс орнуудад нийтлэг тулгамдаж буй сорилтуудыг 5 хүрээнд багцлан гаргасан; эдгээр нь, Төрийн үйлчилгээг сайжруулах, Төрийн үйл ажиллагаанд шударга байдлыг нэмэгдүүлэх, Төрийн нөөц, эх үүсвэрийг үр дүнтэйгээр удирдах, Аюулгүй амьдрах орчин, нөхцлийг бүрдүүлэх, Компаний хариуцлага, эргэн тайлагналыг нэмэгдүүлэх зэрэг юм.

| | | |
|---|---|---|
| **Хамаарал:**<br>*/НЗТ-ийн зарчмуудад нийцэх байдал/* | ✓ Ил тод, нээлттэй байдал<br>✓ Хариуцлагатай байдал<br>✓ Иргэдийн оролцоо<br>✓ Технологи, инноваци | |
| **Үйл ажиллагааны зорилтот үр дүн:**<br>*/Засгийн газрын үйл ажиллагааг хэрхэн илүү нээлттэй болгож, сайжруулж буй талаар товчхон тодорхойлох/* | Төрийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй, шинэ дэвшилтэт технологи нэвтэрсэн, эргэн тайлагнадаг болсон байх. | |
| **Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд**<br>*/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа/* | Эхлэх хугацаа: | Дуусах хугацаа: |
| 1. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11 төвийн өнгөрсөн 2 жилийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх. | 2016.08.01 | 2016.09.01 |
| 2.Хөндлөнгийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11 төвийн үйлчилгээ, үр дүнг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх техник, технологийн арга зам, хувилбарыг тодорхойлох. | 2016.09.01 | 2016.11.01 |
| 3. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11 төвийн үйлчилгээнд тус төвийн аппликэйшн нэвтрүүлэх техник, контентыг боловсруулж бэлэн болгох. | 2016.12.01 | 2017.03.01 |
| 4. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшны туршилт хийх. | 2017.03.01 | 2017.06.01 |
| 5. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшны update хийх. | 2017.06.01 | 2017.09.01 |
| 6. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшн сервисийн нээлтийн ажиллагаа зарлах. | 2017.09.01 | 2017.10.01 |
| 7. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшныг олон нийтэд сурталчлах, ашиглах, заавар өгөх. | 2017.10.01 | 2017.12.31 |
| 8. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшн сервисийн үйл ажиллагааг тогтвортой ажиллуулах | 2018.10.01 | 2018.06.30 |
| 9. “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах Засгийн газрын 11-11” төвийн аппликэйшн сервисийн үйл ажиллагааны хөндлөнгийн үнэлгээг ТББ-аар хийлгэж, дүгнэлт гаргуулах, олон нийтэд мэдээлэх. | 2018.04.01 | 2018.06.01 |

| ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮСНЭГТ | |
|---|---|
| **ЧИГЛЭЛ:** Боловсрол, эрүүл мэнд | |
| **ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУГААР, НЭР:** 2. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | |
| **Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо**<br>*/Шинээр дэвшүүлж буй зорилт уу эсвэл* | 2016.06.30- 2018.06.30; Хэрэгжиж буй зорилт |

| | | |
|---|---|---|
| *хэрэгжиж буй зорилт юм уу?/* | | |
| **Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг** | | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,<br>Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| **Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр** | | Төрийн нарийн бичгийн дарга нар,<br>ЭМСЯ-ны Стратегиийн бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Оюунханд, |
| **Газар, хэлтсийн нэр** | | ЭМСЯ-ны Стратегиийн бодлого төлөвлөлтийн газар,<br>БСШУЯ-ны Стратегиийн бодлого төлөвлөлтийн газар |
| **Майл хаяг** | | - |
| **Утас** | | - |
| **Бусад оролцогч талууд** | **Яам, агентлаг** | Зарим нэг аймгууд болон дүүргүүдийн засаг даргын нийгмийн хөгжлийн хэлтэсүүд, мөн боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд |
| | **Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд** | Нийгмийн хариуцлагын төлөөх төвийн болон орон нутгийн ТББ-ууд |
| | **Олон улсын байгууллага** | Швейцарын Хөгжлийн Агентлаг болон Дэлхийн Банкны хамтарсан санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Монгол Улсад Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх” Төсөл |
| **Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт** | | Боловсрол болон эрүүл мэндийн салбарын үйлчилгээн чанар, хүртээмжийн хувьд сүүлийн жилүүдэд сайжирч байгаа боловч нийт системийн хувьд нөөц, эх үүсвэрүүдийн дутмаг байдал нь эдгээр салбаруудын дорвитой хөгжилд бэрхшээл учруулсаар байна.<br><br>Иймд санхүүгийн ихээхэн нэмэлт эх үүсвэрийн шаардлагагүйгээр төрөөс олон нийтэд үзүүлэх үндсэн гол үйлчилгээнүүд болох боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, мөн олон нийт ялангуяа орлого багатай, мөн зорилтот бүлгүүд, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад ихээхэн анхаарах шаардлага, хэрэгцээ их байна.<br><br>Нийгмийн эгэх хариуцлага буюу үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон үйлчилгээ хүлээн авагч иргэдийн хоорон дох бүтээлч, үр дүнтэй харилцаа болон түншлэл нь энэхүү шаардлагыг хангах нэг боломжит арга зам юм. |
| **Гол зорилт** | | Боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээний талаарх мэдээллийг ойлгомжтой энгийнээр олон түмэнд түгээж, ашиглахад амраар мэдээллийн сувгуудад байрлуулах. Мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ба хэрэглэгчдийн буюу иргэдийн хооронд дахь харилцааг сайжруулж, харилцан бүтээлч харилцаа мөн оновчтой санал, оролцоо, үр дүнтэй эргэх холбоо бий болгоно. Энэхүү алхмууд нь боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээ, түүний хүртээмжийг сайжруулахаас гадна эдгээр салбаруудын тогтолцоог сайжруулахад ихээхэн ач холбогдолтой юм. |
| **Үйл ажиллагааны товч тодорхойлолт**<br><br>*(140 тэмдэгтийн хязгаартай)* | | 2 салбарын үйлчилгээний тухай мэдээллийн агуулгыг сайжруулж, түгээх сувгуудыг нэмэгдүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон иргэдийн хоорондох бүтээлч харилцаа, харилцан хариуцлага тооцох харилцаа болон үр дүнтэй түншлэлийн санаачлагуудыг хэрэгжүүлнэ. |

| **НЗТ-ийн аль сорилтод хамаатай болох** | Төрийн үйлчилгээг сайжруулах | |
|---|---|---|
| **Хамаарал:**<br>*/НЗТ-ийн зарчмуудад нийцэх байдал/* | ✓ Ил тод, нээлттэй байдал<br>✓ Хариуцлагатай байдал<br>✓ Иргэдийн оролцоо<br>✓ Технологи, инноваци | |
| **Үйл ажиллагааны зорилтот үр дүн:**<br>*/Засгийн газрын үйл ажиллагааг хэрхэн илүү нээлттэй болгож, сайжруулж буй талаар товчхон тодорхойлох/* | Төрийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй, шинэ дэвшилтэт технологи нэвтэрсэн, эргэн тайлагнадаг болсон байх. | |
| **Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд**<br>*/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа/* | Эхлэх хугацаа: | Дуусах хугацаа: |
| 1. Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээнд тулгамдаж буй нэн тэргүүний асуудлуудыг тусгана.<br><br>2. Тодорхой аймгууд, дүүргүүдэд боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн талуудын оролцоо, харилцан түншлэлийн санаачлагуудыг хэрэгжүүлнэ.<br><br>3. Тодорхой аймаг, дүүргүүдийн боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дотоод болон гадаад мэдээллийн сүлжээг сайжруулж, хэрэглэгч болон үйлчилгээ үзүүлэгч талуудын харилцан эргэх холбоо, улмаар харилцан хүлээх хариуцлагыг сайжруулах. | 1. 2016.08.01<br><br>2. 2016.10.01<br><br>3. 2017.04.01 | 1. 2016.12.31<br><br>2. 2017.07.01<br><br>3. 2018.06.31 |

## НЗТ-ИЙН СОРИЛТ: ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШУДАРГА БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

| ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮСНЭГТ | | |
|---|---|---|
| **ЧИГЛЭЛ:** Иргэдийн оролцоо | | |
| **ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУГААР, НЭР:** 3. Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо | | |
| **Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо**<br>*/Шинээр дэвшүүлж буй зорилт уу эсвэл хэрэгжиж буй зорилт юм уу?/* | | 2016.06.30- 2018.06.30; Шинээр дэвшүүлж буй зорилт |
| **Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг** | | Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| **Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр** | | Төрийн нарийн бичгийн дарга,<br>Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга |
| **Газар, хэлтсийн нэр** | | Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын |
| **Имэйл хаяг** | | - |
| **Утас** | | 97651260626 |
| **Бусад** | **Яам, агентлаг** | Бүх шатны төрийн захиргааны байгууллагууд |

| | | |
|---|---|---|
| **оролцогч талууд** — **Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд** | Нээлттэй нийгэм форум,<br>МҮОНРТ- “Монголын мэдээ” суваг,<br>Хяналт үнэлгээ мониторинг болон бодлогын чиглэлээр ажилладаг ТББ-ууд,<br>Монголын Сэтгүүлчдийн Эвлэл, “Глоб интернэйшнл”<br>http://www.zasag.mn/tunshlel<br>http://www.opengovpartnership.org/ | |
| **Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт** | Төрийн бодлого, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны Ерөнхий Хууль, Хууль Тогтоомжийн тухай хуулиуд батлагдсан. Эдгээр хуулиудын хэрэгжилтэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байна. | |
| **Гол зорилт** | Олон нийтийн эрх ашгийн хөндсөн төрийн захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах. | |
| **Үйл ажиллагааны товч тодорхойлолт**<br>*(140 тэмдэгтийн хязгаартай)* | Дээрх хуулиудад тусгагдсан иргэдийн оролцооны эрхийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, иргэд эрх, үүргээ бодитойгоор хэрэгжүүлэх замаар олон нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргах ажиллагаанд идэвхтэй оролцож шударга ёсыг бэхжүүлэх. | |
| **НЗТ-ийн аль сорилтод хамаатай болох** | Төрийн үйл ажиллагаанд шударга байдлыг нэмэгдүүлэх. | |
| **Хамаарал:**<br>*/НЗТ-ийн зарчмуудад нийцэх байдал/* | ✓ Ил тод, нээлттэй байдал<br>✓ Хариуцлагатай байдал<br>✓ Иргэдийн оролцоо | |
| **Үйл ажиллагааны зорилтот үр дүн:**<br>*/Засгийн газрын үйл ажиллагаар хэрхэн илүү нээлттэй болгож, сайжруулж буй талаар товчхон тодорхойлох/* | Төрийн захиргааны байгууллага, Засаг даргын 2016 оны 07 сарын 01-ээс хойш гарсан иргэн-олон нийтийн эрх ашгийг хөндсөн бүх шийдвэр иргэн-олон нийтийн оролцоог хангаж гарснаар шударга ёсыг бэхжүүлэх | |
| **Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд**<br>*/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа/* | Эхлэх хугацаа: | Дуусах хугацаа: |
| 1. Иргэн-олон нийтийн хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй захиргааны шийдвэр гаргах үйл явцад иргэд хэрхэн тайлбар, санал гаргах талаарх сургалт, сурталчилгаа өргөн хүрээнд явуулах<br>2. Төрийн захиргааны байгууллага, Засаг дарга нар нийтийн эрх ашиг хөндөгдөж болзошгүй асуудлаарх шийдвэрийн төслөө олон нийт танилцаж, санал өгөх хангалттай хугацаанд ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх<br>3. Төрийн захиргааны байгууллага, Засаг дарга нар нийтийн эрх ашиг хөндөгдсөн шийдвэрт иргэдийн оролцоог хангасан байдалд үнэлгээ хийх | 1. 2016.07.01<br>2. 2016.07.01<br>3. 2017.07.01 | 1. 2018.06.30<br>2. 2018.06.30<br>3. 2017.12.01 |

| ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮСНЭГТ | | |
|---|---|---|
| **ЧИГЛЭЛ:** Төсөв, санхүү | | |
| **ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУГААР, НЭР:** 4. Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчны бүрдүүлэх | | |
| **Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо** *\/Шинээр дэвшүүлж буй зорилт уу эсвэл хэрэгжиж буй зорилт юм уу?/* | | 2016.06.30- 2018.06.30; Шинээр дэвшүүлж буй зорилт |
| **Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг** | | Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| **Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр** | | Төрийн нарийн бичгийн дарга,<br>Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга |
| **Газар, хэлтсийн нэр** | | Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын |
| **Имэйл хаяг** | | - |
| **Утас** | | 97651260626 |
| **Бусад оролцогч талууд** | **Яам, агентлаг** | Үндэсний Аудитын газар, Татварын Ерөнхий Газар , Авлигатай Тэмцэх Газар, |
| | **Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд** | Төрийн ил тод байдал, авлига, засаглалын асуудлаар судалгаа шинжилгээ хийн идэвхтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд,<br>МҮОНРТ, МҮХАҮТанхим, улс төрийн намууд |
| **Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт** | | Улс төрийн намуудын санхүүжилтийн асуудал зөвхөн Монгол Улсад төдийгүй олон улсын түвшинд ч анхаарал татсан сэдэв болоод байна. Дотоодын олон тооны судалгааны тайлан, баримт бичгүүдэд улс төрийн намууд хамгийн авлигад өртсөн болон өртөх эрсдэлтэй институцид тооцогдож байгаа ба сонгуулийн санхүүжилттэй холбоотой гарах зөрчлүүд нэмэгдсээр байгаа нь энэ талаарх зохицуулалт иж бүрэн, төгс болоогүйг харуулж байгаа юм. Энэ байдал нь улс төрийн үйл явцыг гажуудуулж, улс төрийн намын төлөвшилд сөргөөр нөлөөлж, сонгууль шударга бус явагдахад хүргэж, нөгөө талаасаа авлига бий болох хөрс суурь болдог нь олон улсын туршлагаас тодорхой байна. Иймд улс төрийн намуудын санхүүжилтийн асуудлыг нарийвчлан зохицуулах, ил тод, нээлттэй, хяналттай, хариуцлагатай болгох шаардлага зайлшгүй тулгамдаж байгаа болно. |
| **Гол зорилт** | | Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн батлуулах, энэ хүрээнд улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох асуудлыг хуульд тусган зохицуулах. |
| **Үйл ажиллагааны товч тодорхойлолт**<br>*(140 тэмдэгтийн хязгаартай)* | | Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн батлуулах, энэ хүрээнд улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох асуудлыг хуульд тусган зохицуулах. |
| **НЗТ-ийн аль сорилтод хамаатай болох** | | Төрийн үйл ажиллагаанд шударга байдлыг нэмэгдүүлэх |
| **Хамаарал:**<br>*\/НЗТ-ийн зарчмуудад нийцэх байдал/* | | ✓ Ил тод, нээлттэй байдал<br>✓ Хариуцлагатай байдал<br>✓ Иргэдийн оролцоо |
| **Үйл ажиллагааны зорилтот үр дүн:**<br>*\/Засгийн газрын үйл ажиллагааг хэрхэн илүү нээлттэй болгож, сайжруулж буй талаар товчхон тодорхойлох/* | | Улс төрийн намын тухай хуулийг “улс төрийн намын санхүүжилтыг нарийвчлан зохицуулж, ил тод, нээлттэй, хяналттай, хариуцлагатай байх” зарчмыг хангаан шинэчлэн батласнаар улс төрийн намуудыг авилгаас ангид байлгах, авлигаас үүдэн гарах аливаа зөрчлийг арилгаж, |

| | | |
|---|---|---|
| | сонгуулиийн үйл ажиллагаа шударга явагдах нөхцөлийг бүрдүүлнэ. | |
| **Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд** *\/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа\/* | Эхлэх хугацаа: | Дуусах хугацаа: |
| 1. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэн найруулсан төслийг Хууль тогтоожийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай” хуулиудад тус тус заасан процессийн дагуу арга хэмжээ төлөвлөх, НЗТ-ийн талуудыг оролцуулах.<br><br>2. Хуулийн төсөлд улс төрийн намуудын санхүүжилтийн асуудлыг нарийвчлан тусгах, үүнд ил тод, хариуцлагатай байдлыг хэрхэн хангах талаар тодорхой заах хуулийг УИХ-аар батлуулах ажлыг зохион байгуулах.<br><br>3. Хуулийн төслийг батлах хүртэл НЗТ-ийн талуудтай хамтран нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах. | 1. 2016.07.01 | 1. 2016.06.01 |

| ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮСНЭГТ | | |
|---|---|---|
| **ЧИГЛЭЛ:** Хэвлэл мэдээлэл | | |
| **ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУГААР, НЭР:** 5. Хэвлэл мэдээллийн эрх зүйн таатай орчныг бий болгох | | |
| **Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо** *\/Шинээр дэвшүүлж буй зорилт уу эсвэл хэрэгжиж буй зорилт юм уу?\/* | | 2016.06.30- 2018.06.30; Шинээр дэвшүүлж буй зорилт |
| **Хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг** | | Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| **Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр** | | Төрийн нарийн бичгийн дарга,<br>Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга |
| **Газар, хэлтсийн нэр** | | Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын |
| **Имэйл хаяг** | | - |
| **Утас** | | 97651260626 |
| **Бусад оролцогч талууд** | **Яам, агентлаг** | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар,<br>УИХ-ын Тамгын Газар, бусад холбогдох байгууллагууд |
| | **Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд** | Төрийн ил тод байдал, авлига, засаглалын асуудлаар судалгаа шинжилгээ хийн идэвхтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд |
| **Шийдвэрлэхээр зорьж буй асуудлын тодорхойлолт** | | Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2014-2016 оны Үйл аижллагааны үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн Хараат бус тайланд хөндлөнгийн шинжээчдийн тусгайлан өгсөн зөвлөмжөөс дөрөвдүгээр зөвлөмжид 2016-2018 оны ҮАҮТ-нд хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарынхантай хамтран хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаар зорилт оруулах тухай тусгажээ. |

| | | |
|---|---|---|
| | Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд улс төрөөс шууд хяналт тогтоохыг оролдож байгаа нь сэтгэл түгшээж байна. Хэвлэл мэдээллийн тоо өсөн нэмэгдэж, 3 сая хүн амтай зах зээлийг бүрэн хангаад байгаа. Томоохон улс төрчид болон бизнес эрхлэгчид ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгслэлийг эзэмших болсон бөгөөд “хамтын ажиллагааны гэрээ” байгуулах болсон бөгөөд эдгээр гэрээнд захиалагчийн талаар сөрөг мэдээлэл цацахгүй байх тухай заалт орсон байдаг. | |
| **Гол зорилт** | Олон улсын хэм хэмжээнд нийцсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай болох.<br><br>Хэвлэл мэдээллийн салбар дахь шударга өрсөлдөөн ба мөн салбарын хөгжлийг дэмжих үүднээс олон улсын нийтлэг хэм хэмжээний дагуу хэвлэл мэдээллийн салбарт ил тод байдлыг хангасан механизм бий болгох.<br><br>Мэдээллийн эх сурвалжаа нуух сэтгүүлчийн эрхийг олгох, хамгаалах.<br><br>Олон нийтийн радио телевизийн тухай хуульд Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг улс төрийн нөлөөнөөс ангид, санхүүгийн хувьд бие даасан байх нөхцлийг хангасан нэмэлт өөрчлөлт оруулах. | |
| **Үйл ажиллагааны товч тодорхойлолт**<br><br>*(140 тэмдэгтийн хязгаартай)* | Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн салбарын ажилчдбн өргөн төлөөлөлтэйгөөр хэлэлцүүлэх, агуулгад тавих хязгаарлалтыг дахин авч үзэж сайжруулан батлуулах, Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар ОНРТ-ийг улс төрийн нөлөөнөөс ангид, санхүүгийн хувьд бие даах эрх зүйн орчинг бүрдүүлэх. | |
| **НЗТ-ийн аль сорилтод хамаатай болох** | Төрийн үйл ажиллагаанд шударга байдлыг нэмэгдүүлэх | |
| **Хамаарал:**<br>*/НЗТ-ийн зарчмуудад нийцэх байдал/* | ✓ Ил тод, нээлттэй байдал<br>✓ Хариуцлагатай байдал<br>✓ Иргэдийн оролцоо | |
| **Үйл ажиллагааны зорилтот үр дүн:**<br>*/Засгийн газрын үйл ажиллагааг хэрхэн илүү нээлттэй болгож, сайжруулж буй талаар товчхон тодорхойлох/* | Сэтгүүлчийн эх сурвалжаа нуух эрх тогтоогдсон, эрх нь хамгаалагдсан, олон улсын хэм хэмжээнд нийцсэн, хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн өмчлөгчдийг ил тод зарлах үүрэг оноосон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай болох, ОНРТ-ийг улс төрийн нөлөөнөөс ангид, санхүүгийн хувьд бие даасан байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | |
| **Үйл ажиллагаа хэрэгжих үе шатууд**<br>*/Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа/* | Эхлэх хугацаа: | Дуусах хугацаа: |

| | | |
|---|---|---|
| 1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг хэлэлцүүлэх, ингэхдээ олон улсын хэм хэмжээнд нийцсэн эсэхт дүгнэлт гаргаж УИХ-д танилцуулах<br>2. Тус хуулийн олон нийтээр хэлэлцэгдсэн, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах сэтгүүлчийн эрхийг тогтоосон, хамгаалсан, Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгчдийн талаар мэдээллийг ил тод болгох заалт бүхий Олон улсын хэм хэмжээнд нийцсэн төслийг өргөн барих<br>3. Хуулийг батлуулах хүртэлх нөлөөллийн үйл ажиллагааг НЗТ-ийн талуудын оролцоотой төлөвлөж, хариуцан ажиллах<br>4. Олон нийтийн радио телевизийн тухай хуульд "... улс төрийн нөлөөнөөс ангид, санхүүгийн хувьд бие даасан..." байх тухай ямар нэмэлт өөрчлөлт байж болох саналыг мэргэжлийн холбоодоос авч, хэлэлцүүлэх<br>5. Хэлэлцэгдэж ойлголцсон нэмэлт өөрчлөлтийг өргөн мэдүүлэх, нэмэлт өөрчлөлтийг хүлээн автал нөлөөллийн үйл ажиллагааг Хэвлэл мэдээллийн салбартай хамтран зохион байгуулах.<br>6. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгчдийн талаар мэдээллийг ил тод болгох асуудлыг хуулиар нэг мөр зохицуулж мөрдүүлэх. | 1. 2016.08.30 | 1. 2017.12.30 |

| ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮСНЭГТ | | |
|---|---|---|
| **ЧИГЛЭЛ:** Авлигын эсрэг тэмцэх | | |
| **ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУГААР, НЭР:** 6. Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр | | |
| **Үйл ажиллагааг эхлэх, дуусгах огноо** *\/Шинээр дэвшүүлж буй зорилт уу эсвэл хэрэгжиж буй зорилт юм уу?/* | | 2016.06.30- 2018.06.30; Хэрэгжиж буй зорилт |
